

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

**/ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ/**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.3."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.4."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.5."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

4.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

3.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

3.3."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

3.4."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

3.5."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

ТАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн бүлэг, зүйл, хэсэг, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжгүй байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын² 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийнэ. Үүнд:

Нэг.Шалгуур үзүүлэлтийг сонгох

Хоёр.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох

Гурав.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

Дөрөв.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь дараах бүтэцтэйгээр боловсруулагдсан байна.

➤ Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэг "Нийтлэг үндэслэл" бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, хуульд хэрэглэгдэх нэр томьёо, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад баримтлах зарчим зэргийг тогтоосон зохицуулалт бүхий;

➤ Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг "Хэрэглэгчийн эрх"-д хэрэглэгчийн эдлэх эрхийг 7 зүйлд багтаан зохицуулсан зохицуулалт бүхий;

➤ Хуулийн төслийн Гуравдугаар бүлэг "Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг" бүлэгт дээрх этгээдүүдийн хэрэглэгчийн өмнө хүлээх үүргийг тогтоосон;

➤ Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэг "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллагын эрх зүйн байдал" бүлэгт хэрэглэгчийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах төрийн захиргааны болон төрийн бус байгууллагын чиг үүргийг тогтоосон;

➤ Хуулийн төслийн Тавдугаар бүлэг "Бусад зүйл"-д хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээг тус тус тогтоосон байна.

¹Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт албан ёсоор хэвлэгдсэн.

²Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гаргаж ирж чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Ойлгомжтой байдал;
- 3.Практикт хэрэгжих боломж;
- 4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- 5.Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдсан болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн болоод хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын тайлантай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний үндсэн дээр хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг урьдчилан тогтоох ажиллагааг явуулах хэрэгтэй байна. Гэхдээ цаг хугацааны боломж хомс байсан тул хэлэлцүүлэг, судалгааны ажлуудаас гаргасан санал, зөвлөмж, талуудын байр суурийг харгалзан үзэх замаар үнэлэх боломжтой гэж үзэж, сонголоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” Хуулийн төсөлд холбогдох этгээдүүдээс ирүүлсэн санал, талуудын байр суурийг тандах байдлаар уг шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хуулийг дагаж мөрдөх этгээдүүд хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэх боломжтой байх гэж үзэж энэхүү шалгуур үзүүлэлт сонгосон болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр уг шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлыг “Хууль

тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу тусад нь тооцохоор шийдвэрлэсэн тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээ уг тайлангаас тусдаа гарахыг энд тэмдэглэе.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Үнэлгээний ажлын энэ хэсэгт аргачлалд заасны дагуу Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ сонгох буюу тогтоож, өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлттэй үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тохируулан үнэлэхэд бэлтгэх юм. Эдгээр үнэлэгдэх зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа буюу голлох ач холбогдолтой, мөн анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож авсан болно.

Өөрөөр хэлбэл, тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ товч бөгөөд оновчтой байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг, хууль зүйн үр дагавар бий болгож буй, агуулгын хувьд чухал ач холбогдолтой, мөн асуудал дагуулах магадлалтай, анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судлан үнэлэх болно.

Шалгуур үзүүлэлт бүрийн хүрээнд үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тоймолбол:

3.1.“Зорилгод хүрэх байдал”шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор тусгагдсан хэрэглэгчийн эрх, худалдагч, үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийн үүрэг, хуулийн төсөлд шинээр орж ирж байгаа цахим худалдаатай холбоотой зохицуулалт зэргийг хуулийн төслийг зорилгыг хангаж чадах эсэхийг үнэлэн тогтоох юм.

Хуулийн төслийн зорилго нь хуулийн төслийн 1 дүгээр зүйлд зааснаар

“Энэ хуулийн зорилт нь бараа, бүтээгдэхүүн /цаашид “бараа” гэх/ худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагын эрх зүйн байдал, түүнтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Өөрөөр хэлбэл хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуультай байх зорилго нь нэг талаас худалдаа, үйлчилгээ эрхлэгч, нөгөө талаас хэрэглэгч гэсэн тэнцвэргүй талуудын хоорондох харилцаанд хэрэглэгчийн эдлэх наад захын эрхийг баталгаажуулах замаар түүнийг хамгаалах явдал юм.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг судлан үзэхэд хууль санаачлагч нь дээр дурдсан багц зорилгыг дэвшүүлж тэдгээрийг хангах үүднээс хуулийн төслийг боловсруулсан байна гэж үзлээ. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалд заасны дагуу хуулийн төсөлд дээрх зорилгод хүрэх чиглэлээр тусгагдсан зүйл, хэсэг, заалтыг сонгон “зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэх юм.

Хүснэгт 1

д/д	ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД ТУССАН ЗОРИЛГО	ЗОРИЛГЫГ ХАНГАХАД ЧИГЛЭГДСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТ
1	Хэрэглэгчийн хамгаалагдах хуулиар эрхийг баталгаажуулах	Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэг “Нийтлэг үндэслэл” Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг “Хэрэглэгчийн эрх” Хуулийн төслийн Гуравдугаар бүлэг “Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг”
2	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үр нөлөөтэй, оновчтой тогтолцоог бий болгох	18 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагын тогтолцоо. 18.1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллагын тогтолцоо нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах төв байгууллага, аймаг, нийслэл дэх нэгж, дүүргийн улсын байцаагчаас бүрдэнэ. 18.2.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төв байгууллага нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар байна. 18.3.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрх зүйн байдлыг энэ хууль болон Өрсөлдөөний тухай хуульд зааснаар зохицуулна. 19 дугаар зүйл. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар түүний бүрэн эрх. 19.1.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлогыг тодорхойлж, улсын хэмжээнд хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

		19.2.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон нутгийн нэгжийн дарга нь улсын ахлах байцаагч байна. 19.3.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчид ижилсэх хувцастай байна. 19.4.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь Өрсөлдөөний тухай хуульд зааснаас гадна хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 19.4.1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, энэ талаарх төрийн бодлогыг боловсруулах. 19.4.2.Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон асуудлаар хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах, хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг хангуулах, үнэлэлт дүгнэлт өгөх, зөрчил гаргасан этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг оногдуулах, 19.4.3.Төрийн хяналтын бусад байгууллагатай давхардсан хяналт шалгалтын ажлыг хийхгүй. 19.4.4.Улсын байцаагчийн хяналт шалгалтын журмыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга баталж мөрдүүлнэ. 19.4.5.Барааны чанар, аюулгүй байдалд итгэмжлэгдсэн лаброториор шинжилгээ хийлгүүлж, дүгнэлт гаргах, 19.4.6.Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал гаргах, 19.4.7. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, арга, туршлагыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, 19.4.8.Хэрэглэгч зах зээлээс эрүүл
--	--	--

	ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, эрэлт хэрэгцээндээ нийцүүлэн хямд бараа, ажил, үйлчилгээ сонгож авах өргөн боломжийг хангахад чиглэгдсэн шударга өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээ авах, 19.4.9.Аж ахуй эрхлэгчидтэй хамтран хэрэглэгчдэд боловсрол, мэдээлэл олгох “Хэрэглэгчийн боловсролын төв”-ийг ажиллуулах, Хэрэглэгчийн боловсролын төвийн ажиллах журмыг Засгийн газар батална. 19.4.10.Хэрэглэгчээс гаргасан өргөдөл, гомдлыг барагдуулах арга хэмжээг авах, шаардлагатай бол өргөдөл, гомдлын үндэслэлийг хянан шалгаж шийдвэрлэх, 19.4.11.Хэрэглэгч, аж ахуй эрхлэгчдэд тухай бүр хүрч үйлчлэх боломжгүй газар зүйн байршлыг харгалзан орон тооны бус улсын байцаагч ажиллуулж болно. Орон тооны бус улсын байцаагч ажиллуулах журмыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга баталж мөрдүүлнэ. 19.4.12.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах улсын байцаагч нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйл, Өрсөлдөөний тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. 19.4.13.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно. Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.
--	---

3.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт:

Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь хуулийг дагаж мөрдөх болон

хэрэгжүүлэх боломжтойгоор боловсруулагдаж чадсан уу? Дагаж мөрдөх боломж байгаа юу? Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх байгууллага, хуулийн этгээд нь тодорхой эсэх, тодорхой бол тэдгээр этгээдэд зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо бодит байдалд байгаа эсэхийг урьдчилан тогтоох шаардлагын үүднээс уг шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

“практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн дараах зохицуулалтыг үнэлэх болно. Үүнд:

➤ 19.4.9.Аж ахуй эрхлэгчидтэй хамтран хэрэглэгчдэд боловсрол, мэдээлэл олгох “Хэрэглэгчийн боловсролын төв”-ийг ажиллуулах, 21.1.2. хэрэглэгчдэд хэрэглээний мэдлэг, соёл эзэмшүүлэх сургалт зохион байгуулах, хэрэглэгчийн мэдээлэл, үйлчилгээний төвийг ажиллуулах,

➤ 12.6.Зах зээлд гаргасан бараа, ажил, үйлчилгээнд хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулж болзошгүй байдал илэрвэл үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч энэ тухай олон нийтэд мэдээлж, зах зээлээс нэн даруй татан авна.

➤ 16.1.Цахим худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь энэ хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хэрэгжүүлнэ.

16.1.1. Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна,

16.1.2. Байнгын суурин хаяг, өөрийн цахим хуудастай байна,

16.1.3. Зөвхөн өөрийн цахим хаягаар худалдаа, үйлчилгээ эрхэлнэ,

16.1.4.Борлуулсан бараа, ажил, үйлчилгээг баримтжуулах, нотлох үүргийг аж ахуй эрхлэгч хариуцна,

16.1.5.Цахим худалдаатай холбоотойгоор хэрэглэгчийн талаар олж авсан мэдээллийг бусдад задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй байх,

17 дугаар зүйл. Цахим худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь борлуулж байгаа бараа, ажил, үйлчилгээний талаар дараах мэдээллийг ил тод, үнэн зөв, ойлгомжтой байдлаар хэрэглэгчид өгнө.

17.1. бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэгчийн мэдээлэл,

17.2. санал болгож буй бараа, ажил, үйлчилгээний талаарх хэрэглэгчид шаардлагатай мэдээллүүд,

17.3. бараа, ажил, үйлчилгээний захиалга авах, өгөх, хүргэх хугацаа, хэлбэр, төлбөрийн нөхцөл,

17.4. бараа, ажил, үйлчилгээг буцаах нөхцөл,

17.5. баталгаат хугацаа болон борлуулалтын дараах үйлчилгээ,

17.6. хэрэглэгч холбоо тогтооход шаардлагатай мэдээллүүд,

17.7.Цахим худалдаагаар хийж байгаа барааг хэрэглэгчтэй тохиролцсон байршил, цаг хугацаанд хүргэж өгнө.

3.3."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт:

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн төслийн зохицуулалт нь холбогдох төрийн байгууллага, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага болон бизнес эрхлэгчдийн сайн дурын нэгдэл зэрэг эрх, ашиг сонирхлыг тодорхой хэмжээгээр хөндөж байгаа болно. Иймд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн зохицуулалтыг холбогдох этгээдүүд буюу хуулийн төсөл нь хууль болон батлагдсанаар уг хуулийн зохицуулалтыг үр дагаварт шууд өртөх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх үү гэдгийг "хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар урьдчилан тогтоох юм.

Иймд энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс холбогдох этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан, шинэ төрлийн үүрэг, тогтолцоо бий болгосон зэрэг агуулга бүхий зохицуулалтыг сонгон авч үнэлэх болно.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслөөс "хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр дараах зохицуулалтыг үнэлэхээр сонгон авлаа. Үүнд:

➤ 12.2.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, үйлчилгээний газрууд дэргэдээ хэрэглэгчдэд бараа, үйлчилгээний талаар мэдээлэл өгөх, хэрэглээ үйлчилгээний соёлд нэвтрүүлэх, зөвлөгөө өгөх, хэрэглэгчийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч барагдуулах чиг үүрэг бүхий хэрэглэгчдэд үйлчлэх нэгжтэй байна.

3.4."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд шууд, нэг мөр ойлгон хүлээн авахуйц, дагаж мөрдөхөд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдаж чадсан эсэхийг тогтоох үүднээс уг шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг болон түүнийг дагалдан гарах бусад хуулийн төслийг бүхэлд нь үнэлэх болно.

3.5."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг "харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар тогтоох юм. Уг шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг үнэлэхдээ тодорхой стандарт асуултуудад

хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах тул хуулийн төслийн тодорхой зүйл, заалт, зохицуулалтыг бус төслийг бүхэлд нь сонгон авч үнэлэх нь зүйтэй байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 5 бүлэг, 23 зүйлтэй тул эдгээр нь бүгд энэ шалгуур үзүүлэлтээр үнэлэгдэх юм.

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно. *Хүснэгт 2*

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Практикт турших
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа
4	Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
5	Харилцан уялдаа	Харилцан уялдааг шалгах

4.1.ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ:

4.1.1.а."Хэрэглэгчийн хуулиар хамгаалагдах эрхийг баталгаажуулах" зорилгыг хангах хуулийн төслийн зохицуулалтын талаар:

Баян, ядуу, боловсрол, мэргэжил, нас, хүйс харгалзахгүйгээр хүн бүр хэрэглэгч байдаг билээ. Бид өөрт хэрэгцээтэй бараа, бүтээгдэхүүний, ажил, үйлчилгээг санал болгож буй этгээдээс авах замаар хэрэгцээгээ хангадаг болно. Энэ утгаараа хэрэглэгчийн язгуур эрх, ашиг сонирхлыг хамгаалах, баталгаажуулах асуудал нь 1800-аад оноос үүсэлтэй бөгөөд дэлхийн улс орнууд хэрэглэгчийн эрхийг хүлээн зөвшөөрч, дотооддоо болон олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалсан байдаг байна.

Хэрэглэгчийн эрх нь хүний эрхийн дотор хамгийн өргөн хүрээг хамардаг эрхийн төрөл бөгөөд хүн болж төрсөн хэн бүхэнд хамааралтай нийтлэг эрх юм. 1962 онд АНУ-ын Ерөнхийлөгч Джон Кеннеди конгресст үг хэлж, ард түмэндээ гаргасан илгээлтдээ хэрэглэгчийн үндсэн эрхийг анх удаа шинжлэх ухааны үндэслэлтэй, эмх, цэгцтэйгээр дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Амь нас, эрүүл мэндэд аюултай бараа худалдан авахаас хамгаалагдах эрх буюу аюулгүй бараа бүтээгдэхүүнээр хангагдах эрх;
- Хэрэглэгчийг хууран мэхэлсэн, төөрөгдүүлсэн, мэдээлэл, зар сурталчилгаа, хаяг хийх нөхцөл бололцооноос хамгаалагдах эрх

буюу бодит мэдээлэл авах эрх;

- Аль болох өрсөлдөх үнэ бүхий олон нэрийн бараа бүтээгдэхүүнээр хангагдах эрх буюу сонголт хийх эрх ;
- Төрийн бодлогыг боловсруулах үед хэрэглэгчийн ашиг сонирхлыг харгалзан үзэх, тэдний гомдлыг шүүх шударгаар шийдвэрлэх явдлыг хангуулах эрх буюу санаа бодлоо илэрхийлэх эрх" гэжээ.

НҮБ-ын Ерөнхий ассамблей 1985 онд "Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад баримтлах үндсэн зарчим"-ыг баталсан бөгөөд ингэхдээ дээр дурдсан 4 эрх дээр нэмж дараах 4 эрхийг шинээр тодорхойлсноор хэрэглэгчийн үндсэн 8 эрхийг тунхагласан байна. Үүнд:

- Зайлшгүй хэрэгцээтэй эд юмс, үйлчилгээ болон шаардлага хангахуйц хоол хүнс, хувцас хунар, орон байр, боловсролтой, ариун цэвэр, эрүүл мэндийн нөхцөл, хангамжаар хангагдсан байх эрх буюу үндсэн хэрэгцээгээ хангуулах эрх;
- Шаардлага хангаагүй үйлчилгээ, чанаргүй бараа, буруу ташаа мэдээллийн улмаас учирсан хохирлыг барагдуулах үүднээс нөхөн төлбөр авах эрх буюу учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх;
- Хэрэглэгчийн үндсэн эрх, үүрэг хариуцлагыг ухамсарлах, энэ талаар үйл ажиллагаа явуулах, өөртөө бүрэн итгэлтэй, мэдлэгтэйгээр бараа, бүтээгдэхүүний сонголт хийхэд шаардлагатай мэдээлэл, дадлага, чадварыг олж авах эрх буюу хэрэглэгчийн боловсрол эзэмших эрх;
- Одоо болон ирээдүй үеийнхэн аюул занал нүүрлээгүй, сайн сайхан орчинд ажиллаж амьдрах эрх буюу аюулгүй орчинд амьдрах эрх³ гэсэн байна.

Монгол Улс дээрх олон улсын баримт бичигт 1992 онд нэгдэн орсон бөгөөд хэрэглэгчийн эрхийг хүлээн зөвшөөрч, дотоодын хуулиар баталгаажуулсан нь одоо шинэчилсэн найруулга хийгдэж байгаа Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль юм. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь одоо үйлчилж байгаа Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар тогтоосон хэрэглэгчийн эрхтэй холбоотой материаллаг зохицуулалтыг бараг өөрчлөөгүй буюу яг хуучин хэвээр нь хадгалан үлдээсэн байдлаар бичигдсэн байна.

Хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлж өгөөгүй бөгөөд энэ нь хуулийг хэрэглэхэд ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Мөн хуулийн зорилтыг тодорхой харилцааг зохицуулах гэж чиглүүлсэн нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн ач холбогдлыг бууруулсан шинжтэй болсон байна.

Монгол Улс хэрэглэгчийн эрхийг хамгаалах бие даасан хуультай хэдий ч өнөөдөр ч хэрэглэгчийн эрх зөрчигдөх явдал амьдрал дээр байнга тохиолддог

³"Цахим" сэтгүүл, 2016 он

боловч үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчийн эрхийг хүндэтгэх, сахин биелүүлэх хандлага төдий л төлөвшөөгүй байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуульд хэрэглэгчид учирсан гэм хорыг арилгах асуудал тусгагдсан байдаг боловч энэ нь зөвхөн учирсан бодит хохирлоор хязгаарлагдаж байгаа бөгөөд сэтгэл санааны хохирол буюу "аюулгүй бараа бүтээгдэхүүнээр хангагдах эрх"-д учирсан хохирлыг арилгахааргүйгээр томъёологдсон байсныг хуулийн төсөл дэвшилтэд шатанд гаргаагүй байна.

Өөрөөр хэлбэл буруутай этгээдийн хэрэглэгчид учруулсан хохирлын эдийн гэм хорын хэмжээнээс үл харгалзан сэтгэл санааны хохирлыг тогтоох, арилгах асуудал хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "8.1.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас хэрэглэгчид учирсан гэм хорыг арилгах, хохирлыг нөхөн төлөх талаар гаргасан хэрэглэгчийн шаардлагыг үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч биелүүлэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллагад гомдол гаргана." гэсэн нь нэг талаасаа Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан шүүхэд хандах эрх зүйн боломжийг хязгаарласан байна гэж үзэхээр байна. Хуулийн төслийн гипотезийг харвал хэрэглэгч тодорхой бараа, бүтээгдэхүүн нь чанарын шаардлага хангахгүй байсан тохиолдолд эдийн бус гэм хороо мөнгөөр төлүүлэх боломж хууль тогтоомжид байхгүй бөгөөд эдийн гэм хор болох тухайн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авахад зарцуулсан мөнгийг нөхөн төлөх талаар гаргасан хэрэглэгчийн шаардлагыг буруутай этгээд нөхөн төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд хэрэглэгч холбогдох байгууллагад хандах эрхтэй байхаар тусгасан байна.

Мөн хуулийн төсөлд хэрэглэгчийн хүсээгүй бараа, бүтээгдэхүүнийг худалдан авахгүй байх буюу сонгох эрхийн талаар зохицуулалт бараг байхгүй гэж үзэж болохоор байна.

Зах зээлийн харилцаа өргөжин тэлж байгаа энэ үед худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн зүгээс өөрийн үндсэн бараа бүтээгдэхүүнийг дагалдуулан хэрэглэгчийн хүсээгүй бусад бараа, бүтээгдэхүүнийг "иж бүрдэл" нэрийн дор хэрэглэгчид хүчээр тулгах явдал байдаг. Тухайлбал зээлдэгч нь хэрэглэгчид зээл олгохдоо даатгалыг худалдан авахыг шаардаж байгаа үед хэрэглэгч хэд хэдэн даатгалын байгууллагаас өөрөө сонголт хийх боломжтой байх буюу хэрэглэгчийн сонгох эрхийг баталгаажуулах шаардлагатай байна. Үүнтэй холбоотойгоор хэрэглэгчийн сонголт хийх эрхийг хангаагүй тохиолдолд тухайн бараа бүтээгдэхүүнийг солих буюу буцаах эрхийн асуудал ч мөн хөндөгдөж болох юм.

Хуулийн төсөлд хэрэглэгчийн эрхийг тодорхойлохдоо олон улсын баримт бичгээр тогтоосон жишиг, бусад хөгжингүй улс орнуудын хандлагыг харгалзан үзэж, системтэйгээр тодорхойлж, дахин томъёолох шаардлагатай байна. Түүнчлэн зарим шаардлагагүй буюу хэрэглэгдэхгүй, бусад хуулиар нэгэнт зохицуулсан хэм хэмжээг хуулийн төслөөс хасах нь зүйтэй. Тухайлбал хуулийн төслийн 11 дүгээр зүйл "Хэрэглэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байх"

гэсэн нь тодорхой үр дагаваргүй бөгөөд хэлцэл хүчин төгөлдөр байх нөхцөлийг Иргэний хуулиар зохицуулсан байх тул уг зүйлийг хасах нь зүйтэй.

Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүргийг тодорхойлсон хоёрдугаар бүлэг нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтыг бараг хэвээр үлдээсэн бөгөөд зөвхөн "гаргасан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлээс нэн даруй татан авах" үүргийг хуулийн төсөлд оруулж ирсэн байна. Энэ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, олон тооны хэрэглэгч хохирохоос хамгаалах ач холбогдолтой зохицуулалт болсон хэдий ч хуулийн этгээдийн хүлээх үүргийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн дахин томъёолох шаардлагатай байна.

Ингэхдээ өнгөрсөн хугацаанд хуулийг хэрэгжүүлэхэд зөвхөн зохион байгуулалтаас гадна материаллаг эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор ямар хүндрэл, бэрхшээл тулгарч байсныг тодорхой судалгаан дээр тулгуурлан тогтоох шаардлагатай байна. Тухайлбал худалдаа эрхлэгч нь худалдаа явуулахдаа холбогдох хуулийн дагуу хэрэглэгчид худалдан авалт хийснийг нотлох баримт олгох, албан ёсны борлуулагч нь хэрэглэгчид учирсан хохирлыг шууд барагдуулж, үйлдвэрлэгчээс өөрт учирсан хохирлыг барагдуулах зэрэг хэрэглэгчид ээлтэй байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай.

4.1.1.6.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үр нөлөөтэй, оновчтой тогтолцоог бий болгох зорилгыг хангах зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байдлын талаар:

Хэрэглэгчийн хуулиар тогтоосон эрхийг хамгаалахын тулд улс орон бүр тодорхой бүтцийг ажиллуулах байгаа болно. Хуулийн төсөлд Дөрөвдүгээр бүлэг "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллагын эрх зүйн байдал" гэсэн нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог зохицуулсан зохицуулалт агуулсан байна. Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллагын тогтолцоо нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах төв байгууллага, аймаг, нийслэл дэх нэгж, дүүргийн улсын байцаагчаас бүрдэнэ." гэж заасан байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь бүх салбарын байгууллагын хэрэглэгчийн өмнө хүлээх үүргийн хэрэгжилтийг хангах, зохицуулах эрх бүхий байгууллага юм. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал хариуцсан ерөнхий чиг үүрэгтэй төрийн агентлаг юм. ШӨХТГ нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний болон Зар сурталчилгааны тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулах, тодорхой эрх, үүрэгтэй бөгөөд Иргэний хууль түүнтэй уялдуулан гаргасан бүхий л хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах эрхтэй⁴ боловч мэргэшсэн ажилтны тоо цөөн, нөөц бололцоо хангалтгүй байгаагаас хуулийн хэрэгжилтэд хангалттай хяналт тавьж чадахгүй байгаа талаар Дэлхийн банкнаас хийсэн "Монгол Улс дахь хэрэглэгчийн эрх ашгийг, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношлогоо" тайлан эмхтгэлд дурдсан байна. Түүнчлэн уг тайланд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль дахь ШӨХТГазрын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг маш өргөн хүрээтэй

⁴Өрсөлдөөний тухай хуулийн 2 дугаар зүйл

тавигдсан бөгөөд хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал нь бүхий л салбарыг хамарч байгаатай холбоотойгоор зарим байгууллагатай чиг үүрэг давхардах, нөгөө талдаа уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөөц боломж хүрэхгүй байгаа дүгнэлтэд хүрсэн байна.

Иймээс хуулийн төсөлд туссанаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагыг орон нутагт салбар нэгжтэй болгож байгаа явдал нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг төр бодлогоор дэмжиж байгаа хэрэг юм.

Харин хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлгийн томьёоллыг улам бүр боловсронгуй болгох, хуулийн үйлчлэх хүрээг, эсхүл ШӨХТГ-аар хяналт тавих чиг үүргийн хүрээг бусад хууль тогтоомжтой уялдуулан нарийвчлан боловсруулах шаардлагатай.

Тухайлбал санхүүгийн салбарын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй байж болох төрийн гурван ч байгууллага байгаа бөгөөд /Монгол Банк, Санхүүгийн зохицуулах хороо, ШӨХТГ/ тэдгээрийн чиг үүрэг өөр хоорондоо хэрхэн уялдах бие биеэ хэрхэн нөхөх зэрэг асуудал ойлгомжгүй байдаг.

Иймд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд хэрэглэгчийн эрхийн тухай асуудал нь бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээтэй болохыг харгалзаж, зөвхөн ШӨХТГ-аар хязгаарлахгүйгээр төрийн бусад байгууллагыг холбогдох салбарт хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар тодорхой чиг үүрэгтэй болох талаар зохицуулалт тусгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах нь зүйтэй байна.

Түүнчлэн хуулийн төслийн 22 дугаар зүйлд "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагын чиг үүрэг"-ийг тогтоосон зохицуулалт тусгасан нь бүлгийн нэртэй нийцэхгүй байх тул бүлгийн нэрийг өөрчлөх эсхүл, төрийн бус байгууллагатай холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг буюу хэрэглэгчийн эрхийн нэг төрөл байдлаар тусгах нь зүйтэй байна.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чухал нөлөөтэй асуудал бол хэрэглэгчийн эрхийн зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын тухай асуудал юм. Хуулийн төслийн тавдугаар бүлэгт хууль тогтоомж зөрчигчдөд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр томьёолсон байна.

Хуулийн төслийг дагалдуулж Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулаагүй байх тул одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хариуцлагын хэм хэмжээг хэвээр үлдээсэн гэж үзэж болохоор байна.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай эрх зүйн зохицуулалтаар хууль тогтоомж зөрчигч нь хэрэглэгчид эдийн хохирол учирсан тохиолдолд хохирлыг барагдуулдаг, сэтгэл санааны хохирол тооцох боломжгүй буюу эдийн хохирол гэдэгт зөвхөн тухайн бараа бүтээгдэхүүний худалдан авахад зарцуулсан мөнгөн хөрөнгийг барагдуулах тухай зохицуулалттай байгаа нь ихээхэн шүүмжлэл дагуулж байгаа энэ үед хууль тогтоомж зөрчигч этгээдэд гаргасан зөрчилд тохирсон хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох зохицуулалтыг хуулийн төсөлд эсхүл холбогдох хуульд тусгах нь зүйтэй байна.

Учир нь аж ахуй эрхлэгч нь ашиг орлого олох зорилгодоо хэт улайран зарим тохиолдолд хуулийн зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг зөрчсөний төлөө хүлээх

хариуцлагаа урьдчилан тооцоолж хууль зөрчих явдал тохиолддог тул гаргасан зөрчилд тохирсон мөнгөн дүн бүхий хариуцлага хүлээлгэх замаар эрсдэлээс хэрэглэгчийн эрхийг хамгаалдаг бусад улс орны туршлагыг харгалзах нь зүйтэй.

4.1.2. “ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хуулийн төсөлд практикт хэрэгжих боломжийг урьдчилан тогтоох шаардлагатай дараах агуулга бүхий зохицуулалт тусгагдсан байна. Үүнд:

4.1.2.а.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19 дүгээр зүйлийн 19.4.9 дэх заалт “Аж ахуй эрхлэгчидтэй хамтран хэрэглэгчдэд боловсрол, мэдээлэл олгох “Хэрэглэгчийн боловсролын төв”-ийг ажиллуулах, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт “хэрэглэгчдэд хэрэглээний мэдлэг, соёл эзэмшүүлэх сургалт зохион байгуулах, хэрэглэгчийн мэдээлэл, үйлчилгээний төвийг ажиллуулах” заалт нь практикт хэрэгжих боломжтой юу?

Дээр дурдсан ёсоор хуулийн төсөлд тусгагдсанаар “Хэрэглэгчийн боловсролын төв”⁵, “Хэрэглэгчийн мэдээлэл, үйлчилгээний төв”⁶ гэсэн хоёр төрлийн бүтэц ажиллахаар хуулийн төсөлд тусгагдсан байна.

“Хэрэглэгчийн боловсролын төв”-ийн тухайд: ийм бүтэц ажиллуулах тухай заалт хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.4.9 дэх заалт буюу хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага болох Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын бүрэн эрхийг зохицуулсан хэсэгт тусгагдсан байна. Энд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь аж ахуй эрхлэгчтэй хамтран, хэрэглэгчдэд боловсрол, мэдээлэл олгох “Хэрэглэгчийн боловсролын төв”-ийг ажиллуулах бүрэн эрхтэй бөгөөд мөн төвийн ажиллах журмыг Засгийн газар батлахаар тусгагдсан байна.

Энэ нь ямар бүтэц байх вэ? Уг бүтцийг бүрдүүлж байгаа этгээд нь нэг талаас төрийн байгууллага, нөгөө талаас аж ахуй эрхлэгч байхаар байна. Аж ахуй эрхлэгч гэдгийг хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь хэсэгт Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтад тодорхойлсныг ойлгохоор заасан байна. Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтад “аж ахуй эрхлэгч” гэж Монгол Улсад бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг,” гэж заасан байна.

Эндээс маш ойлгомжгүй нөхцөл байдал үүсэж байна. Аж ахуй эрхлэгч нь ашгийн төлөө ч бай, төлөө бус ч бай хамгийн гол нь аж ахуй эрхэлж байх ёстой бөгөөд хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд, хувь хүн байх боломжтой байна.

⁵Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19 дүгээр зүйлийн 19.4.9 дэх заалт

⁶Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт

Эндээс Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 19.4.9 дэх заалт ямар зорилгоор тусгагдсан нь тодорхой нөхцөл байдлыг үүсгэж байна. Түүнчлэн хууль батлагдан гарсны дараа Засгийн газар уг төвийн ажиллах журмыг батлахад аж ахуй эрхлэгч гэдэг нь өргөн хүрээтэй байгаагаас их төвөгтэй байдал үүсгэхээр байна.

Ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй эрхлэгчтэй төрийн захиргааны байгууллага хамтарсан бүтэц байгуулах нь ашгийн төлөө байх уу? Ашгийн төлөө бус байх уу зэрэг олон асуудал дагуулахаар байна.

Хуулийн төсөлд дээрхээс гадна аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийг зохицуулсан 21 дүгээр зүйлд тэдгээр этгээдүүд нь хэрэглэгчдэд хэрэглээний мэдлэг, соёл эзэмшүүлэх сургалт зохион байгуулах хэрэглэгчийн мэдээлэл, үйлчилгээний төвийг ажиллуулах бүрэн эрхтэй байхаар заасан байна.

Хуулийн төслөөс үзвэл Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь аж ахуй эрхлэгчтэй хамтран “Хэрэглэгчийн боловсролын төв” ажиллуулах бол аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрт Засаг дарга нар нь “Хэрэглэгчийн мэдээлэл, үйлчилгээний төв” ажиллуулахаар байна. Хэрэглэгчийн боловсролын төв нь улсын хэмжээнд нэг байх эсхүл хэд хэд байх нь тодорхойгүй бөгөөд энэ нь төрийн байгууллага байх, төрийн бус байгууллага байх, ашгийн төлөө байх, ашгийн төлөө бус байх асуудал төсөлд тодорхойгүй байна.

Мөн засаг захиргааны нэгж бүрт “Хэрэглэгчийн мэдээлэл, үйлчилгээний төв” ажиллах хэрэгцээ шаардлага тодорхойгүй бөгөөд хуулийг хэрэгжүүлэхэд маш их хэмжээний зардал гарахаар байна.

Иймд хэрэглэгчийн хэрэглээний талаар мэдлэг, мэдээлэл олж авах эрхийг хангахын тулд заавал шинэ төрлийн бүтэц нэмэх байдлаар тусгасан нь хуулийн төслийн хэрэгжих боломжийг бууруулж байна. Түүнчлэн хуулийн төслийн бичилтийн томъёоллыг дахин эргэж харах буюу хуулийн төслийн 19.4.9, 21.1.2 дахь хэсэгт заасан байгууллагуудын ижил зорилготой нэг байгууллага мөн эсэх, ийм байгууллага ажиллах хэрэгцээ шаардлага байгаа эсэх, байгаа бол хаана, хэрхэн ажиллахыг тодорхой тоо баримт дээр тулгуурлан судалсны үндсэн дээр хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна.

4.1.2.6.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 12 дугаар зүйлийн“12.6.Зах зээлд гаргасан бараа, ажил, үйлчилгээнд хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулж болзошгүй байдал илэрвэл үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч энэ тухай олон нийтэд мэдээлж,зах зээлээс нэн даруй татан авна. “ хэсгийн практикт хэрэгжих боломжийн талаар:

Зах зээлд гаргасан бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ нь бизнес эрхлэгчийн тооцоолоогүй сөрөг үр дагавар үүсгэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулж болзошгүй нөхцөл байдал үүсгэх тохиолдол бодит байдалд тохиолддог бөгөөд үүнээс болж хэрэглэгч хохирсон жишээ ч мөн байгаа нь нууц биш юм.

Иймээс хуулийн төсөлд энэ үүргийг аж ахуй эрхлэгч этгээдэд ногдуулж өгсөн нь оновчтой боловч хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад зохицуулалт хуулийн төсөлд байхгүй байна. Өөрөөр хэлбэл хуулийн этгээд уг заалтыг хэрхэн хэрэгжүүлэх, хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээх болон ажил, үйлчилгээний төрлийн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлж байгаа тохиолдолд нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэх нөхцөл байдлыг хуулийн төслийн уг заалтын гипотезд нэмж өгөх, хуулийн төсөлд тусгагдсан нөхцөл байдал үүссэн гэдгийг хэн тогтоох, ямар нэг эрх бүхий байгууллагын оролцоогүйгээр уг аж ахуй эрхлэгч өөрөө уг нөхцөл байдал бий болсон гэж үзэх эсэх зэрэг асуудлыг тодорхой болгох шаардлагатай.

Хуулийн төслийн зохицуулалтыг үзэхэд аж ахуй эрхлэгч нь өөрөө зах зээлд гаргасан бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ нь хэрэглэгчид аюултай нөхцөл байдал үүсгэж болзошгүй гэж үзэхээр байгаа бөгөөд өөрөө тийм нөхцөл байдал үүсээгүй гэж үзвэл өөр эрх бүхий байгууллага уг харилцаанд оролцох зохицуулалт байхгүй байгаа нь хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг бууруулах магадлалтай байна.

Иймд уг заалтыг бүрэн хэрэгжих боломжийг олгох бусад зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай.

4.1.2.в. Цахим худалдаа, үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой хуулийн төслийн зохицуулалтын практикт хэрэгжих боломжийн талаар:

Хуулийн төсөлд орж ирж байгаа зарчмын шинжтэй, томоохон зохицуулалтын нэг бол цахим худалдаа, үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой зохицуулалт юм.

Хуулийн төсөлд тусгагдсанаар цахим худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд хэлбэрээр байгуулагдсан⁷, өөрийн цахим хуудастай, зөвхөн өөрийн цахим хаягаар худалдаа үйлчилгээ эрхлэхээр заажээ.⁸ Цахим хуудас гэдгийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн⁹ 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад “цахим хуудас” гэж нийтэд нээлттэй байдлаар интернет сүлжээнд байрлуулсан цахим баримт бичиг, мэдээллийг” гэж тодорхойлсон байна.

Хуулийн төслийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт “аж ахуй эрхлэгч” гэдгийг тодорхойлохдоо Өрсөлдөөний тухай хуулийг ишлэн хэрэглэсэн бөгөөд мөн хуульд аж ахуй эрхлэгчийг “Монгол Улсад бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг” гэснийг хэрэглэж цахимаас бусад бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгчид хувь хүн, ашгийн төлөө бус хуулийн

⁷Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт

⁸Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.3 дах заалт

⁹Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2011 оны №26 дугаарт нийтлэгдсэн.

этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээдийг хамруулсан байж цахим худалдаа, үйлчилгээ эрхлэгчийг хуулийн этгээдийн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулахаар заасан нь хуулийн төслийн зохицуулалтын зөрчлийг бий болгож байгаагаас гадна, ийнхүү заавал хуулийн этгээд байхаар заасан нь ямар ач холбогдолтой нь тодорхой харагдахгүй байна.

Мөн үүнийг хянаж чадах эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдүүдийн талаарх судалгаа, мэдээлэл, бүртгэл хаана ч байхгүй бөгөөд цаашид тэднийг заавал хуулийн этгээд хэлбэрээр үйл ажиллагаагаа явуул гэж шаардах нь практикт хэрэгжих боломжийг бууруулах, нууц, далд хэлбэрт шилжсэнээр хэрэглэгчийн эрхийг илүү хохироох нөхцөлийг бүрдүүлж болзошгүй байна.

Мөн нөгөө талаас хэрэглэгч нь заавал хуулийн этгээдээс худалдаа, үйлчилгээг авч байх шаардлагыг бий болгож байгаа нь хэрэглэгчийн худалдагч, үйлдвэрлэгчийг сонгох эрхийг хязгаарласан гэж үзэж болохоор байна.

Цахим худалдаа, үйлчилгээ нь хэрэглэгчийн эрхийг зөрчих магадлал уламжлалт худалдаатай харьцуулбал илүү өндөр бөгөөд хэрэглэгчид учрах энэ эрсдэлээс хамгаалсан зохицуулалт тусгах шаардлагатай байна. Цахим сүлжээнд байрлуулсан бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний талаар мэдээлэл болон хэрэглэгчийн гар дээр очиж байгаатай нийцэж байх, цахим сүлжээгээр дамжуулан худалдаалж байгаа бараа, ажил, үйлчилгээг өөрөө үйлдвэрлээгүй бол үйлдвэрлэгчийн талаарх, тухайн бараа бүтээгдэхүүний хэрэглээний шаардлага хангаж буй эсэхийг борлуулахаас өмнө урьдчилан тогтоох арга хэмжээ авсан байх зэрэг тухайн цахим худалдаа эрхлэгчид хэлбэрийн төдий шаардлага тавихаас илүүтэйгээр нэгэнт бий болсон уг харилцаанаас хэрэглэгч хохирохгүй байх нөхцөлийг хангахад чиглэсэн зохицуулалтыг тусгах шаардлагатай байна

Нөгөө талаас “цахим худалдаа, үйлчилгээ эрхлэгч” гэж субъектэд хамааралтай зохицуулалт тусгаснаар хуулийн хийдэл үүсэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл мэдээллийн технологийн энэ үед аж ахуй эрхлэгч бүр олон нийтийн цахим сүлжээг ашиглан бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээгээ танилцуулах, сурталчлах, борлуулах зэргээр цахим орчинг маркетингийн нэг арга хэрэгсэл болгон ашиглаж байгаа энэ үед цахим үйл ажиллагаанд нь буюу цахимаар бараа, ажил, үйлчилгээг худалдах, борлуулахад чиглэсэн байдлаар хуулийн төслийн зохицуулалтыг томъёолох нь хэрэглэгчийн эрхийг хамгаалахад илүү чиглэгдэх зохицуулалт болох юм.

4.1.3.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ:

Уг үнэлгээний тайлангийн 3.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслөөс сонгож авсан дараах зүйл, хэсэг, заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг урьдчилан үнэлбэл:

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт “Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, үйлчилгээний газрууд дэргэдээ хэрэглэгчдэд бараа, үйлчилгээний талаар мэдээлэл өгөх, хэрэглээ үйлчилгээний соёлд нэвтрүүлэх, зөвлөгөө өгөх, хэрэглэгчийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч барагдуулах чиг үүрэг бүхий хэрэглэгчдэд үйлчлэх нэгжтэй байна.” гэсэн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх үү?

Энэ заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэхийн тулд дараах асуултад хариулт өгөхөөр байна.

1.Хуулийн төслийн дээрх зохицуулалтыг хууль хүчин төгөлдөр батлагдвал хэн дагаж мөрдөх вэ?

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллага, үйлчилгээний газрууд дагаж мөрдөхөөр төсөлд тусгагдсан байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг” ойлгоно гэж заасан байна.

Харин “байгууллага” гэсэн нэршилд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй төрийн болон төрийн бус байгууллага байхаар ойлгогдож байгаа бол “үйлчилгээний газар” гэдгийг аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж гэдэгт багтаан авч үзвэл Монгол Улсад үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээд хамааралтай байхаар хуулийн төсөл уншигдаж байна.

Дагаж мөрдөх этгээд тодорхой болсон тул хуулийн төслийн дагуу дээр дурдсан субъект нь “дэргэдээ хэрэглэгчдэд бараа, үйлчилгээний талаар мэдээлэл өгөх, хэрэглээ үйлчилгээний соёлд нэвтрүүлэх, зөвлөгөө өгөх, хэрэглэгчийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч барагдуулах чиг үүрэг бүхий хэрэглэгчдэд үйлчлэх нэгжтэй” байх гэсэн үүргийг хэрэгжүүлэхээр байна.

Хуулийн төсөл сонгох боломжгүй буюу уг заалтыг заавал биелүүлэх агуулгаар бичигдсэн байна. Улсын бүртгэлийн байгууллагын бүртгэлийн албан ёсны хуудас болох www.burtgel.mn цахим хуудсанд 2018 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар хязгаарлагдмал хариуцлагатай компани, сан, төрийн бус байгууллага, шашны байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, хоршоо, хадгаламж зээлийн хоршоо, төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, гадаад улсын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар зэрэг ангиллаар 178260 хуулийн этгээд бүртгэлтэй¹⁰ байгаа талаар статистик мэдээ байна.

¹⁰ www.burtgel.mn

Эдгээр дотроос үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүх байгууллага хуулийн төслийн дээр заалтад хамаарахаар байна.

Үүнийг аж ахуйн нэгж, байгууллага хүлээн зөвшөөрөх үү?

Тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, жилийн борлуулалтын эргэлт, ажилтан, албан хаагчийн тоо, шууд эцсийн хэрэглэгчтэй харилцдаг эсэхийг харгалзалгүйгээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг бол тухайн хуулийн этгээдийн том, жижиг, ямар нэг нөхцөл байдлыг харгалзан үзэхгүйгээр “хэрэглэгчдэд үйлчлэх нэгж” ажиллуулахыг даалгах нь үйл ажиллагааны зардлаа аль болох арга байлгахыг зорьдог аж ахуйн нэгжийн хувьд хүлээн зөвшөөрөгдөхгүй байх магадлал өндөртэй юм.

Хэрэглэгчийг дээдлэх нь тухайн аж ахуйн нэгжийн цаашдын хөгжил, ашиг, орлогод шууд хамааралтай эцсийн зорилго тул түүнийг заавал биелүүлэх үүрэг байдлаар оруулах нь хуулийн этгээдэд дарамт үзүүлэх магадлалтай байна. Хэрэглэгчдийг соён гэгээрүүлэх, тэднээс ирүүлсэн өргөдөл гомдлыг барагдуулах асуудал нь гарцаагүй боловч үүнийг заавал нэр заасан нэгжээр дамжуулан хийх эсэх асуудал нь тухайн хуулийн этгээдийн өөрсдийн шийдвэрлэх асуудал юм.

Тиймээс уг зохицуулалтыг хуулийн төсөлд байлгах шаардлагатай бол дагаж мөрдөх хуулийн этгээдүүдэд тодорхой болзол хангасан байх, бусад хуулийн этгээдийн хувьд заавал нэгж байгуулахгүйгээр хэрэглэгчийн гомдлыг шуурхай шийдвэрлэхийг үүрэгжүүлэх байдлаар томьёолох нь зүйтэй юм.

Хэрэглэгчийг хэрэглээний боловсрол олж авах, мэдээллээр хангагдах эрхийг хангах нь төр, хувийн хэвшил, хэрэглэгчийн зэрэг бүх талуудын ашиг сонирхлыг хөндсөн асуудал болохыг анхаарч, уг эрхийг баталгаажуулах зорилгоор уг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан бол ашиг сонирхол нь хөндөгдөж буй талууд даган биелүүлэх боломжтой, тэдэнд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар тусгах нь зүйтэй. Түүнчлэн хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхийн тулд маш их хэмжээний зардал гарах болохыг анхаарах шаардлагатай.

4.4. “ХАРИЛЦАН УЯЛДАА” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хүчин төгөлдөр бусад хууль тогтоомжтой болон өөр хоорондоо болон Монгол Улсын бусад хууль тогтоомжтой харилцан уялдаж нэгдмэл болж чадаж байгаа эсэх асуудлыг тогтоох юм.

Хуулийн үйлчлэх хүрээ тодорхойгүй буюу хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг огт зааж өгөөгүй байна. Үүнээс улбаатайгаар хуулийн төслийн 19.1, 19.4.1 дэх заалтад тус тус зааснаар Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар нь хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулахаар заасан байна.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж гэдэгт зөвхөн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиас гадна санхүүгийн, хүнс, үйлчилгээ

зэрэг олон салбарт хэрэглэгчийн эрхтэй холбоотой зохицуулалт бүхий хуулиудад тус байгууллага хэрэгжилтийг хангах үүрэгтэй байхаар ойлгогдож байна. Гэтэл салбар бүрийн хууль тогтоомжид хуулийн хэрэгжилтийг хангуулах байгууллагыг зааж өгсөн байдгаас төрийн холбогдох эрх бүхий байгууллагуудын эрх хэмжээ давхардах, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байх зэрэг нөхцөл байдал үүсэхэд хүргэж байна.

Иймд хуулийн үйлчлэх хүрээг тогтоох, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө байгууллагын эрх хэмжээг бусад хууль тогтоомжтой уялдуулан одоо үүсээд байгаа давхардал, хийдлийг арилгах байдлаар хуулийн төсөлд тусгах нь зүйтэй.

Хуулийн төслийн 19.4.9 дэх заалт, 21.1.2 дахь заалтуудаар тус тус хэрэглэгчдэд хэрэглээний соёл эзэмшүүлэх, сургалт зохион байгуулах адил төстэй чиг үүрэг бүхий "Хэрэглэгчийн боловсролын төв", "Хэрэглэгчийн мэдээлэл үйлчилгээ төв" гэсэн байгууллагыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ажиллуулахаар заасан байна.

19.4.9 дэх заалтад заасан бүтцийг ШӨХТГ нь аж ахуй эрхлэгчтэй хамтран ажиллуулахаар заасан. Гэтэл нь мөн хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллага бүрийг хэрэглэгчдэд үйлчлэх нэгжтэй байхыг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгээр хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагын чиг үүргийг хэрэглээний соёлын талаар сургалт явуулах, зөвлөгөө өгөх байхаар тус тус зохицуулсан байна.

Хэрэглэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, боловсрол олгох асуудлыг маш олон талд тусгаж өгөхдөө хооронд харилцан уялдаагүй, давхардуулан, зарим тохиолдолд тухайн бүтэц нь Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн ямар хэлбэртэй байх, хэрхэн ажиллах зэрэг олон ойлгомжгүй байдал үүсгэсэн байх тул хэрэглэгчийн боловсролыг дэмжих зорилго бүхий зохицуулалтыг эргэн харж, оновчтой байдлаар дахин боловсруулах шаардлагатай байна.

Цахим худалдаа эрхлэгчийн талаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд ийнхүү тусгахдаа заавал хуулийн этгээд хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулахыг шаардсан байна. Гэтэл хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтад "аж ахуй эрхлэгч" гэдгийг тодорхойлохдоо Өрсөлдөөний хуулийг ишлэн хэрэглэж, хувь хүнийг хамруулсан байгаа зөрчилдөж байгааг анхаарах шаардлагатай. Энэ талаар зохицуулалтыг боловсронгуй болгох талаарх саналыг "практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн үнэлгээний хэсэгт дурдсан болно.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллагын тогтолцоог "хэрэглэгчийн эрхийг хамгаалах төв байгууллага, аймаг, нийслэл дэх нэгж, дүүргийн байцаагчаас бүрдэнэ" гэж зааснаар тус байгууллага нь аймаг, нийслэлд нэгжтэй, дүүрэгт улсын байцаагчтай байхаар ойлгогдож байна. Гэтэл хуулийн төслийн 21 дүгээр зүйлээр "аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга"-д тодорхой үүрэг хүлээлгэсэн байгаа нь суманд бүтэц ажиллах эсэх талаарх ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.4.13 дахь заалтад "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно. Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална" гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад "тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж дэмжих" гэж тус тус заасан байна. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно" гэж заасантай хуулийн төслийн дээрх зохицуулалт зөрчилдөж байх тул нийцүүлэх шаардлагатайг анхаарах.

Хуулийн төсөлд нэг мөр ойлгогдохгүй, хоёрдмол утга бүхий зохицуулалт ихээр агуулагдсан байна. Тухайлбал 19 дүгээр зүйлийн 19.4.7 дахь заалтад заасан "арга, туршлагыг нэвтрүүлэх" гэсэн нь ямар арга туршлагыг хаана нэвтрүүлэх нь ойлгомжгүй, 19.4.10 дахь заалтад "шаардлагатай бол өргөдөл, гомдлын үндэслэлийг хянан шалгаж шийдвэрлэх" гэсэн нь шаардлагатай бус болон шаардлагатай гэдгийг хэн тогтоох нь тодорхойгүй бөгөөд энэ нь шаардлагатай, шаардлагагүй тухай ойлголт бус хуульд заасан үндэслэл байвал зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явагдах тул хуульд нийцүүлэн томьёолох шаардлагатай.

Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээ тусгагдсан боловч түүнийг зөрчсөн тохиолдолд авах хариуцлагын зохицуулалтыг тусгаагүй байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөөд 15 жил болж байгаа хэдий ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байсан шалтгаан нь нэг талаас хуулийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн байдал тодорхойгүй, нөгөө талаас хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо оновчгүй байсантай холбоотой юм. Иймд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг үр нөлөөтэй, оновчтой болгох нь хуулийн шинэчилсэн найруулга хийх зарчмын гол асуудал гэдгийг анхаарч хариуцлагын зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

ТАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судлаачийн хувиар Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлэх ажиллагааг хийлээ.

Хуулийн төслийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалыг чанд баримтлан, аргачлалд заасан дараах шалгуур үзүүлэлтийг сонгон авч, уг шалгуур үзүүлэлтийг илтгэх зүйл, хэсэг, заалт бүрийг үнэлэв. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал
- Практикт хэрэгжих боломж
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- Харилцан уялдаа

Хуулийн төсөлтэй холбоотой санал, дүгнэлтийг шалгуур үзүүлэлт бүрийн хэсэгт тодорхой дэлгэрэнгүй бичсэн бөгөөд түүнийг дараах байдлаар тоймлож байна.

Хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлж өгөөгүй бөгөөд энэ нь хуулийг хэрэглэхэд ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Мөн хуулийн зорилтыг тодорхой харилцааг зохицуулах гэж чиглүүлсэн нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн ач холбогдлыг бууруулсан шинжтэй болсон байна.

Монгол Улс хэрэглэгчийн эрхийг хамгаалах бие даасан хуультай хэдий ч өнөөдөр ч хэрэглэгчийн эрх зөрчигдөх явдал амьдрал дээр байнга тохиолддог бөгөөд үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчийн эрхийг хүндэтгэх, сахин биелүүлэх хандлага төдий л төлөвшөөгүй байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуульд хэрэглэгчид учирсан гэм хорыг арилгах асуудал тусгагдсан байдаг боловч энэ нь зөвхөн учирсан бодит хохирлоор хязгаарлагдаж байгаа бөгөөд сэтгэл санааны хохирол буюу “аюулгүй бараа бүтээгдэхүүнээр хангагдах эрх”-д учирсан хохирлыг арилгахааргүйгээр томъёологдсон байна.

Иймд хуулийн төслийг шинэчилсэн найруулга хэлбэрээр бичиж байгаа тул одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн бүтцэд баригдалгүйгээр хуулийг бүхэлд нь өөрчилж, эрх зүйн соёл ойролцоо бусад улс орны туршлагыг судалсны үндсэн дээр хэрэглэгчийн эрхийн хамгааллын асуудлыг одоо байгаагаас шат ахиулах шаардлагатай.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай тогтолцооны талаар хуулийн төсөлд зохицуулалт тусгасан боловч хэрэглэгчийн эрхийн тухай асуудал нь бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээтэй болохыг харгалзаж, зөвхөн ШӨХТГ-аар хязгаарлахгүйгээр төрийн бусад байгууллагыг холбогдох салбарт хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар тодорхой чиг үүрэгтэй болох талаар зохицуулалт тусгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах нь зүйтэй байна.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай эрх зүйн зохицуулалтаар хууль тогтоомж зөрчигч нь хэрэглэгчид эдийн хохирол учирсан тохиолдолд хохирлыг барагдуулдаг, сэтгэл санааны хохирол тооцох боломжгүй буюу эдийн хохирол гэдэгт зөвхөн тухайн бараа бүтээгдэхүүний худалдан авахад зарцуулсан мөнгөн хөрөнгийг барагдуулах тухай зохицуулалттай байгаа нь ихээхэн шүүмжлэл дагуулж байгаа энэ үед хууль тогтоомж зөрчигч этгээдэд гаргасан зөрчилд тохирсон хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох зохицуулалтыг хуулийн төсөлд эсхүл холбогдох хуульд тусгах нь зүйтэй байна.

Хуулийн төсөлд нөхцөл байдал, томъёолол зэргээс хамааран хэрэгжих боломж нь эргэлзээтэй зохицуулалт тусгагдсан бөгөөд үүнд тухайлбал

"Хэрэглэгчийн боловсрол, мэдээллийн төв"-ийг аж ахуйн нэгж бүр болон хэрэглэгчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрт ажиллах нь хэрэгжих магадлал муутай бөгөөд маш их хэмжээний зардал үүсгэхээр байгааг анхаарч хэрэгцээ, шаардлагыг харгалзан зорилтод бүлгийг оновчтой тодорхойлох шаардлагатай.

Хуулийн төслийн үг хэллэг, утга найруулга, томьёолол зэргийг Хууль тогтоомжийн тухай болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцүүлэн боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

-----oOo-----

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЛААР

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2018 онд Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд нар баталсны дагуу тус хуулийн төслийг боловсруулсан.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7, 20.8 дахь хэсэгт заасны дагуу Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус тус зөвшөөрөл авч, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсэгт заасны дагуу 2019 оны 09 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар төсөвт ямар нэгэн зардал гарахгүй тул тусгайлсан зардлын тооцоо хийх шаардлагагүй болно.

Хуулийн анхны төсөлд хэрэглэгчдэд мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх, соён гэгээрүүлэх ажил хийх төвтэй мөн орон нутагт орон тооны ажилтан, улсын байцаагчтай байх заалтууд тусгагдсан боловч Сангийн яамнаас "Төрийн албаны орон тоог нэмэгдүүлэхгүй байх зарчим"-д нийцэхгүй байна гэдэг үндэслэлээр төсвөөс нэмэлтээр гарах зардалтай холбоотой заалтуудыг хас гэсэн шаардлага тавьсны дагуу холбогдох заалтуудыг хассан болно.

Иймд тус хуулийн төсөлд зардлын тооцоо хийх шаардлагагүй болно.

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН, ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ОЛОН НИЙТЭЭС САНАЛ АВАХААР ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ТАЛААР

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын afccp.gov.mn цахим хуудсанд 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу олон нийтээс санал авахаар Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүний үзэл баримтлал хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланг тус тус байршуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасны дагуу санал авч дуусах хугацаа 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдөр байсан боловч энэ хугацаанд иргэдээс нэг ч санал ирүүлээгүй болно.



БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ВИДЕО МЭДЭЭ ИЛ ТОД БАЙДАЛ МЭДЭЭ МЭНДЧИЛГЭЭ
НҮҮР ХУУДАС ТҮҮХЭН ЗАМНАЛ ХӨЛБӨӨ БАРИХ ШИНЭН ДАНС ЭРХЭМ ЗОРИЛГО

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ
ГАЗАР



Archives

- November 2019
- October 2019
- September 2019
- August 2019
- July 2019
- June 2019
- May 2019
- April 2019
- March 2019

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон нийтийн саналыг хүлээн авч байна.

Та хуулийн төсөлтэй холбоотой саналаа munguntsetseg@afccp.gov.mn цахим хаягаар болон бичгээр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт хандан ирүүлнэ үү

Лавлах утас: 51-263675

Санал авах хугацаа: 12-р сарын 1 хүртэл

Доорх холбоосоор татаж авна уу.

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
2. Үзэл баримтлал
3. Тандалт, судалгааны тайлан

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН САНАЛ

Хугацаа: 2019 оны 1-р сарын 25-ны өдөр 10 цаг

Байрлал: Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын хурлын танхим

Д/д	Санал гаргасан газар	Саналын утга	Хуулийн төсөлд тусгасан эсэх
1	ХЭАХҮН-ийн БСШУС-ын удирдах зөвлөлийн тэргүүн Х.Баавгай:	Хүүхдийн эрх хүний эрхийн конвенцыг аваад үзэхээр нийгэм, соёлынхоо хэрэгцээг хангуулах санаа байдаг. Хуулийн төсөлд энэ санаа байхгүй байна. Хүүхэд бол онцгой хэрэглэгч. Үүнийг нэр томъёондоо оруулах. Хүүхдийг онцгой хэрэглэгч гэж үзвэл хүүхэд өөрөө хэрэглээний соёлтой байх асуудал, эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдэд аюулгүй хэрэглээг хангах үүрэг хүлээх учраас ерөнхий заалт оруулах хэрэгтэй. 3.1.1 Хэрэглэгч гэдэг нэр томъёог өргөтгөж бичих. Тухайлбал гэр бүл гэдэг хэсгийг гэр бүлийн эдийн засаг, нийгэм, соёл, ахуйн хэрэгцээг хангахад нь зориулж гэж. 3.1.3.Халамжийн тухай хуульд заасан тодорхойлолтыг гэж оруулсан байсан. 3.1.1-д хуулиар гэснийг хуулийн гэж өөрчлөөд хуулийн 3.2 – 3.8-ийг гэж оруулж өгвөл Халамжийн хуулийн хүрээ нь тодорхой болж гарч ирнэ. 12 дугаар зүйлийг мэдээлэл авах, хэрэглээний соёл эзэмших гэж өөрчлөх 20.1-д байгаа томъёоллыг ойлгомжтой болгох	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийтлэг эрхэд хамаарч байгаа. Хуульд ялган, зааглаж тусгах шаардлагагүй. Нэр томъёоны тодорхойлолтод өргөн утгаар хамаарагдаж байгаа. Саналыг хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслөөс хассан.
2	Нийслэлийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн захирал С.Тойвгоо:	3.1.2-ийг дахиж ярих хэрэгтэй байна. Аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн гэж заасан байна. Гэтэл тухайн хүн гэртээ хувийн жижиг үйлдвэрлэл явуулдаг бөгөөд худалдаж авсан бараа, бүтээгдэхүүн дээр асуудал яригдвал хэрхэх вэ? Энэ нөхцөлд үйлдвэрлэл явуулдаг хүнийг буруутгах уу. 5.5–д байгаа заалтыг 23 дугаар зүйлийн эрх, үүрэгтэйгээ зохицолдуулах. Төрийн бус байгууллагаар яаж хамгаалуулах гэдгээ тодруулж өгөхгүй бол хамгаалах зүйл нь тодорхойгүй байна. Хэрэглээний хэсэгт ухаалаг хэрэглээ, сонголттой гэсэн нэр томъёог оруулах санал байна.	Аж ахуй, бизнесийн үйл ажиллагааны харилцааг иргэний хуулиар зохицуулдаг. Саналыг хуулийн төсөлд тусгасан. Шаардлагагүй

	15.1.1.-д Тогтоохгүй юмыг тогтоох гээд байх шиг. Энэ заалтыг хасах.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
	17.2-д Үр ашигтай тогтолцоог бий болгох. Өнөөдрийн бидний хийгээд байгаа зүйл үр ашиггүй юу. Энд тогтолцоог бий болгох биш боловсронгуй болгох асуудал арай оновчтой.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
	17.3. Энд холбогдох хуульд заасныг үндэслэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх шийдвэр гаргах. Шийдвэр гарчих юм байна. Журам, гүйцэтгэж болох ажил, үйлчилгээний жагсаалтыг гаргах. Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, хийж болох ажил үйлчилгээний жагсаалтыг Засгийн газраас батлаад өгвөл бидэнд амар байх болно.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
	18.3-д Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага болон салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагатай хамтран ажиллана гэж. Энэ бол манай хэдийг онцгойлон авч үзсэн заалт байгаа. Энд заавал салбарын гэж алагчлах хэрэг байна уу. Явцуу утгаар нь салбарын гэх нь хэн нэг хүнд үйлчлэх санаа байна.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
	19.1.2-д жил бүр дүгнэлт хийх гэж оруулах	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
	19.1.5-д Тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллагатай бүтээгдэхүүн нийлүүлэх болон хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хөрөнгийн эх үүсвэрээр дэмжлэг үзүүлэх гэж оруулах	Бусад холбогдох нийцэхгүй	хуульд
	21.2.1-д Бусад салбарын гэж хэлэхгүйгээр хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, энэ талаар төрийн бодлогыг боловсруулж батлуулна гэдэг утгаар нь оруулах	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
	21.2.4-д Лаборатори гэхийг Монгол хэлээр бичих	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
	21.2.5-д Санал гаргах гэдгийг тодруулах. Бид санал гаргаад боловсруулах юм уу.	Хуулийн төсөлд тодорхой байгаа.	хуулийн төсөлд
	21.2.12-д Хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын орон нутгийн нэгжийн дарга нь улсын ахлах байцаагч байна. Орон нутгийн нэгжийн дарга гэж нэг үг байгаа. Тогтолцооны нэгж гэдэг нь ойлгомжгүй байгаа. Байгууллагын дотоод ажилтай холбоотой асуудлуудыг тусгасан байна. Үүнийг хуулиар зохицуулах шаардлага байхгүй болов уу.	Хуулийн төслөөс хассан.	

		22.1.2-д Хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ байдаг байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харъяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр хянан шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, гэхийг хэвээр нь байлгах.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
3	Шинжилгээ, судалгаа, сургалт, хэрэглэгчийн төвийн захирал С.Буянхишиг.	5 дугаар бүлгийн нэрийг агуулгын хувьд хянах. Тухайлбал төрийн бус байгууллага гэдгийг нягтлах. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагын бүрэн эрх гэж оруулах	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
4	ХЭАХҮН-ийн ХАА-ны салбарын гүйцэтгэх захирал Ц.Долгорсүрэн:	Эдэлгээний хугацаа гэдгийг хасаж болохгүй. Хүнсний бүтээгдэхүүнд заавал байх ёстой гэдгийг хэлмээр байна. Бусад зүйлс давхцаж байна. Мөн 5-р бүлгийн төрийн бус байгууллага гэдэг нэр байх ёстой гэж үзэж байна.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
5	ХЭАХҮН-ийн банк, санхүүгийн салбарын тэргүүн Ц.Жигдэн:	20-р зүйл. Тогтолцоог эргэн харах. Байгууллага, хүн хоёр холилдоод тогтолцоо болдог гэх зүйлээ эргэн хараад төрийн болон төрийн бус байгууллага гэж оруулах хэрэгтэй. Тогтолцоон дотроо төрийн байгууллага гэдгээ хэлээд төрийн байгууллага дотроо хэрэглэгчийн байгууллага, засаг захиргаа зэрэг байгууллагууд нь орж томьёолсон байдлаар санааг нь оруулах. Түүний цаад талд иргэний нийгмийн байгууллагыг оруулах.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
6	Сонгинохайрхан ХЭАХНийгэмлэгийн Ш.Ишжамц:	Бараа гэдэг ойлголтыг дангаар нь оруулахгүйгээр 3.1.9-д ажил, үйлчилгээ гэж байна. Эдгээрийг нэг газар нь томьёолох.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
		Иргэний нийгмийн байгууллагуудын үүргийг тодорхойлох, хүчтэй болгох. Тухайлбал улсын байцаагчийн эрх, статусыг олгох талаар агуулгыг нэмэх	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
		Иргэний нийгмийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх. Тухайлбал яам, тамгын газруудын хяналт шалгалтын төсвийн багцаас хуваарилах талаар агуулгыг оруулах.	Энэ хуулийн агуулгад хамаарахгүй тул оруулах боломжгүй.	хуулийн агуулгад
		Бүтэцдээ төрийн болон иргэний нийгмийн байгууллага гэж оруулах. Төрийн бус байгууллагыг оролцоог чухалчлах.	Шаардлагагүй	
		Арбитартай байх. Энэ арбитар нь ШӨХТГ-т эсвэл хэрэглэгчийн эрхийг хамгаалах иргэний нийгмийн байгууллагууддаа байх.	Тусдаа зохицуулагддаг	хуулиар
		Худалдагч эдэлгээний хугацааг тогтоохгүй. Эдэлгээний хугацааг буруу тогтоосон тохиолдолд тухайн үйлдвэрлэгч хариуцна. Мөн энэ хуулийн заалтад худалдагч байгууллага гэж оруулах	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд

7	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны С.Өнөрбилэг:	Цахим худалдааны хяналт хэрхэн хийгдэж байгаа вэ? Үүнийг тодруулах	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
8	ХЭАХҮН-ийн ЭМХНХ салбарын тэргүүн Б.Батбаатар:	9.2-д Үйлчилгээ үзүүлэгчдэд гэсэн үгийг нэмж оруулах. 14.1-д Холбогдох баталгаат сэлбэг, хэрэгслийн гэж нэмж оруулах	Саналыг тусгасан. Саналыг тусгасан.	хуулийн төсөлд хуулийн төсөлд
9	ХЭАХҮН-ийн БОАЖ-ын салбарын тэргүүн С.Энхбат:	21.2.6-д Урамшуулах, сурталчилгаа гэж юм байх ёстой. Жишээлбэл сайн байгууллагуудын үйл ажиллагааг урамшуулах, бусдад таниулах, сурталчлах үүднээс сурталчлах гэсэн агуулгыг нэмэх 6 дугаар бүлэг хариуцлагын тогтолцоог Өрсөлдөөний тухай хуулийн агуулгаар зүйлчилж оруулах саналтай байна.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
10	ХЭАХҮН-ийн ХАА-н салбарын гүйцэтгэх захирал Ц.Долгорсүрэн:	18.3-д салбарын орон нутгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэж оруулах. Бүх хэрэглэгчийн байгууллагыг хамрагдахаар оруулах.	Саналыг тусгасан.	хуулийн төсөлд
11	ХЭАХҮН-ийн БСШУС-ын салбарын тэргүүн Д.Төмөрдорж:	1-р зүйлд Боловсрол гэдэг бол оюуны хэрэглээ юм. Тиймээс боловсрол эзэмшигч гэж хуулийн төслийн эхний хэсэгт оруулах. 22.2-т албан бус болон насан туршийн тасралтгүй боловсрол эзэмших гэж оруулах. Мөн зайны болон цахим сургалт гэж тодотгож оруулах	Саналыг тусгасан. Саналыг тусгав.	хуулийн төсөлд хуулийн төсөлд



МОНГОЛЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН
ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ
НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ҮНДЭСНИЙ
ХОЛБОО

Монгол улс. Улаанбаатар хот.
Сүхбаатар дүүрэг 8-р хороо. Амарын
гудамж. Лобби төвийн 4-р давхар
Утас: 99115423, 91914598
Вэб хуудас: hereglegch.mn
Цахим шуудан: domo0710@yahoo.com

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн
төлөө газрын дарга Б.Лхагва танаа

2019.01.03 № 5/101

Санал хүргүүлэх тухай

Хэлэлцүүлгийн шатандаа байгаа "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" Монгол улсын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулах өмнө нь давхардаж гараагүй саналаа хүргүүлж байна.

Манай саналыг хүлээн авч хуулийн төслийн холбогдох бүлгүүдэд тусган оруулж өгөхийг хүсье.

/саналуудыг хавсаргав/

Таныг хүндэтгэсэн:

Ерөнхий нарийн бичгийн дарга



Ц.Шагжжав

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд өгсөн санал.

2019 оны 1 дүгээр сар 1

Нэгдүгээр бүлэгт дараах заалт нэмэх: 1.2 "Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, Монгол улсын болон олон улсын стандартын шаардлага хангасан баталгаатай импортын бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг дэмжин хөгжүүлж, Монгол хэрэглэгчийн сэтгэлгээг төлөвшүүлэхэд оршино."

Мөн бүлгийн 3.1.7 заалтад: "... цахим худалдаа, гэсний дараа "үйлчилгээ" ... " гэж нэмэх,

Гуравдугаар бүлгийн 16.1.5 заалтад: " цахим худалдаа гэсний дараа "үйлчилгээ" гэж нэмэх,

Дөрөвдүгээр бүлэгт дараах заалт нэмэх: " Салбарынх нь Бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэгчид шууд хүрдэг Төрийн захиргааны төв байгууллага, Агентлаг, Газарт хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал эрхэлсэн орон тооны ажилтан ажиллана."

Мөн бүлгийн 19.4.13 заалтыг "Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон асуудлаар хууль, тогтоомжийн биелэлтийг шалгах, хамтарсан үзлэг явуулах,мэдээлэл сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ТББ аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, тэдэнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх" гэж өөрчлөх,

Мөн бүлгийн 22.4 р заалтыг "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Төрийн төв байгууллага болон мэргэжлийн хяналт, үндэсний стандартчлалын байгууллагатай хамтарсан хяналт шалгалт, зөвлөн туслах ажиллагаанд оролцох, дүнгээ хамтран гаргах, мэдээлэх," гэж өөрчлөх,

Мөн бүлэгт дараах заалтуудыг нэмж томъёолон оруулах, Үүнд:

22.7 "Энэ хуулийн 18.2 байгаа ШӨХТГ ын орон тооны бус гишүүгээр томилуулах хүний нэрийг Засгийн газарт өргөн барих",

22.8 "Хэрэглэгчид учирсан хохиролыг барагдуулах, нөхөн төлүүлэх асуудлаар дэргэдээ Арбитр ажиллуулах",

22.9 "Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудлаар, төрийн эрх барих болон гүйцэтгэх засаглалын байгууллагуудын дэргэд ажиллах орон тооны болон орон тооны бус хороо, зөвлөлүүдэд томилуулах хүний нэрийг эрх бүхий байгууллагад өргөн барих",

22.10 "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, тогтоомжийн хэргэжилтийг хангуулахад шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусгуулан батлуулах саналаа холбогдох байгууллагад өргөн барьж шийдвэрлүүлэх",

Санал боловсруулсан


Ц.Шагжжав. /МХЭАХНҮХ ны ЕНБД/



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ



2018 оны 11 сарын 20 ны өдөр

№ 13

Улаанбаатар хот
Утас: 88051616, 90661616

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН, ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАРТ

Хуулийн төсөлд санал өгөх тухай

Шударга бус өрсөлдөөнийг хориглох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар МУЗГ-ын бусад холбогдох байгууллагууд, аймаг, нийслэл, дүүргүүдийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдтэй хамтран ажиллаж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар удирдлагын төрөл бүрийн түвшинд тулгамдаж байгаа ажлыг уялдуулан зохицуулах талаар анхаарч, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагуудын удирдах ажилтнуудын уулзалт, семинарыг жил бүр хийж, дэмжлэг үзүүлж байдаг бид талархдаг. Саяхан Та бүгдийн зохион байгуулсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах улсын зөвлөлгөөн-сургалт" амжилттай зохион байгуулагдаж, энэ зөвлөлгөөн дээр танилцуулагдсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хуулийн төсөлтэй танилцаад дараах саналуудыг хүргүүлж байна.

1 "Олон улсын гэрээний заалт" гэгч нь ямар гэрээ, ямар заалт нь тодорхойгүй учир төслийн 2.2 дахь хэсэг буюу давхар утгатай заалтыг хасах.

2. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3 дахь заалтанд байгаа "санхүүгийн байгууллага" гэсэн үгийг "аж ахуй эрхлэгч" гэдэг байдлаар хувирган банк, санхүүгийн байгууллагатай холбогдсон заалтыг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулинд давхардуулан тусгах нь зохимжгүй учир төслийн 3.1.6 заалтыг хасах.

3. "Төрийн захиргааны байгууллага" гэж МУЗГ, түүний харъяа яамдууд, аймаг, нийслэл, хотуудын Засаг даргын Тамгын газруудыг, гэсэн заалтыг төслийн 3.1.7 заалт болгож нэмэх.

4. "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллага" гэж Монгол улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн харъяаллаар байгуулагдсан хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгүүдийг, гэсэн заалтыг төслийн 3.1.8 заалт болгож нэмэх.

5. Төслийн 7.1 дэхь хэсэгт дурьдсан: "харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай мэдээлэл бэлтгэж болно" гэж хэрэглэгчдийг ялгаварласан хэсгийг хасах. Ийм хэрэглэгчид харьцангуй цөөн тул хуульчилах шаардлагагүй.

6. Төслийн 9-р зүйлийн нэрийг: Хэрэглээ, үйлчилгээний соёл эзэмших хэрэглэгчийн эрх, үүрэг гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг: Хэрэглэгч нь ажил үйлчилгээ үзүүлэгчид, аж ахуй эрхлэгч нарт хүндэтгэлтэй хандаж,

зүй бус зан авир, үйлдэл гаргахгүйгээр соёлтойгоор үйлчилүүлэх үүрэгтэй гэж тус тус найруулах.

7. Төслийн 12.2 дахь хэсэгт дурьдсан заалт нь аж ахуйн нэгж байгууллагын дотоод ажлыг хэт дэглэх гэсэн агуулгатай байгаа учир хасах.
8. Төслийн 12.5 дахь хэсэгт дурьдсан заалт нь: төрийн захиргааны байгууллагаас өгсөн шаардлагыг заавал биелүүлэх, бусад байгууллагаас өгсөн шаардлагыг яасан ч яахав гэсэн байдал илэрхийлээд байгаа учир хасах.
9. Төслийн 15.2 дахь хэсэгт дурьдсан алдангийн хэмжээг өмнөх хуулийн дагуу 0.1 хувиар байлгах.
10. Төслийн 16 дугаар зүйлийн 17.1- 17.7 дахь хэсгүүдэд дурьдсан 7 заалт нь энэ хуулийн төслийн бусад хэсгүүдэд тусгагдсан шаардлагуудтай давхцаж байгаа учир дээрх хэсгүүдийг хасах.
11. Төслийн Дөрөвдүгээр бүлгийн нэрийг: **Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагуудын эрх зүйн байдал** гэж найруулах.
12. Төслийн 18 дугаар зүйлд дурьдагдсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төв байгууллага нь ШӨХТ газар байна" гэсэн нь МУЗГ болон яамдууд, орон нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулиар заагдсан эрх, үүрэгтэй, МУЗГ-ын тохируулагч агентлагийн статусынхаа хувьд зөрчилдөж байгаа, мөн ШӨХТ газрын байцаагчийн бүтэц, хувцас хэрэглэл зэрэг нэг байгууллагын дотоод асуудалтай холбогдсон энгийн зүйлүүд нь Шударга бус өрсөлдөөнийг зохицуулах тухай хуулийн холбогдох заалтууд, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дотоод дүрэм, журамд тусгагдсан заалтуудтайгаа давхцсан учир, төслийн 18.1-18.3 \3 заалт\, 19.1-19.4.5 \9 заалт\, 19.4.9-19.4.13 \5 заалт\ дахь хэсгүүдийг төслөөс хасах.
13. Төслийн 18.1 дэхь хэсэгт: "Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон төрийн бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг харъяалах Засаг захиргааны байгууллагын түвшинд зохион байгуулж, биелэлтийг шалгах, дүнг мэдээлэх" гэж шинээр оруулах.
14. Төслийн 18.2 дахь хэсэгт: "Хэрэглэгч зах зээлээс эрэлт хэрэгцээндээ нийлүүлэн хямд, аюулгүй, зохих чанарын бараа сонгож авах боломжийг хангаж, шударга өрсөлдөөнийг дэмжих", төслийн 18.3 дахь хэсэгт: "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаарх хууль тогтоомжийн биелэлтэнд холбогдох төрийн бус байгууллагаар хөндлөнгийн дүгнэлт гаргуулах, мэдээлэл, сурталчилгаа хийлгэх, сургалт зохион байгуулах зэрэг асуудлуудаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, гэж тус тус шинээр оруулах.
15. Төслийн 18.4 дэхь хэсэгт: "Хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, ажил үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх" гэж шинээр оруулах.
16. Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэхь хэсгийн заалт нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар төрийн бус байгууллагуудын өөрсдөө бие даан хийх хяналтын эрхийг хязгаарласан гэж ойлгогдохоор заалт байгаа тул 22.4 дэхь хэсгийг хасах.

15 11 19

17. Төслийн 22.? дахь заалтад: "Хэрэглэгчдээс ирүүлсэн санал гомдлуудын ерөнхий агуулга, түүнийг засан сайжруулах асуудлаарх саналыг цаг тухайд нь төрийн захиргааны байгууллагад тавих" гэж оруулах.

18. Төслийн 22.?? дахь заалтад: "Хэрэглэгчийн эрхийг хохироосон тухай үндэслэл бүхий шаардлага хүлээж авсан боловч зөрчил хохиролыг арилгуулахгүй байгаа албан тушаалтны талаар холбогдох дээд шатны байгууллагад мэдэгдэх" гэж оруулах.

19. Төслийн 22.??? дахь заалтанд: "Чанар, аюулгүй байдал хангахгүй байгаа талаар хэрэглэгчдээс ирүүлсэн гомдлыг үндэслэн, тус бүтээгдэхүүнд хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгүүлэх" гэж оруулах.


20. Төслийн 18 дугаар зүйлд, өмнөх хуулийн 16.1 дэхь хэсэгт дурьдсан "Барааны чанар, аюулгүй байдалд итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгүүлж, дүгнэлт гаргуулах" гэсэн заалтыг хэвээр оруулах.

Хуулийн төслийн бусад заалтуудыг дэмжиж байна.

(Хуулбарыг МХЭАХН-үүдийн Үндэсний холбоо, НХЭАХ нийгэмлэгт)

НИЙГЭМЛЭГИЙН ДАРГА

Ш.ИШЖАМЦ



АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

1. Б.ЛХАГВА - ШӨХТГ-ын дарга - 88889818
2. С.ЯНЖИНСҮРЭН - Шадар сайдын зөвлөх - 99119376
3. Н.БЯМБАДОРЖ - ШӨХТГ-ын Орон тооны гишүүн - 99119693
4. Ц.ТЭРБИШ - ШӨХТГ-ын ТЗУГ-ын дарга - 99128897
5. Б.ЦЭРЭНДУЛАМ - ШӨХТГ-ын ХЭХГ-ын дарга - 99030381
6. Т.БАТЦЭЦЭГ - ШӨХТГ-ын ӨБЗГ-ын дарга - 99282398
7. Р.САРАНТУЯА - ШӨХТГ-ын ЗЗСГ-ын дарга - 99096484